



ГАДААД ХУДАЛДАА

I-VI/2025

Тархаасан: 2025 оны 7 дугаар сарын 9

Экспорт өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 1. ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ


Төрөл	Жил			Эхний 6 сард			2025* I-VI 2024 I-VI	
	2022	2023	2024	2023 I-VI	2024 I-VI	2025* I-VI	Зөрүү	Хувь
	сая ам.доллар							
Эргэлт	21 243.0	24 437.1	27 398.0	11 827.0	13 267.4	12 109.6	- 1 157.8	- 8.7
Экспорт	12 538.6	15 186.9	15 783.4	7 553.6	7 889.3	6 581.4	- 1 307.9	- 16.6
Импорт	8 704.4	9 250.2	11 614.7	4 273.4	5 378.1	5 528.2	150.1	2.8
Тэнцэл	3 834.2	5 936.6	4 168.7	3 280.1	2 511.1	1 053.2	- 1 458.0	- 58.1

*Урьдчилсан гүйцэтгэл

Монгол Улс 2025 оны эхний 6 сард нийт 145 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 6.6 тэрбум ам.доллар, импорт 5.5 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 1.1 тэрбум ам.долларын ашигтай гарчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.2 (8.7%) тэрбум ам.доллар, экспорт 1.3 (16.6%) тэрбум ам.доллар, тэнцэл 1.5 (58.1%) тэрбум ам.доллороор тус тус буурч, импорт 150.1 (2.8%) сая ам.доллороор өссөн байна.

ЗУРАГ 1. ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ



Экспорт 2025 оны эхний 6 сард өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллороор буурахад нүүрс 2.1 тэрбум ам.доллар, угаасан ноолуур 148.0 сая ам.доллар, боловсруулаагүй газрын тос 31.4 сая ам.доллар, хонь, ямааны мах 24.3 сая ам.доллар, төмрийн хүдэр, баяжмал 16.7 сая

ам.доллороор тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин зэсийн хүдэр ба баяжмал 897.9 сая ам.доллар, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 55.9 сая ам.доллар, цайрын хүдэр, баяжмал 28.7 сая ам.доллороор өссөн байна.


ЗУРАГ 2. ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ, 2025 оны эхний 6 сард



Импорт өмнөх оны мөн үеэс 150.1 сая ам.доллараар өсөхөд суудлын автомашин 207.6 сая ам.доллар, тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги 21.9 сая ам.доллар, гар утас 15.0 сая ам.доллар, согтууруулах ундаа 14.5 сая

ам.доллар, шороо, чулуу ялгах, холих машин 10.4 сая ам.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин ачааны автомашин 44.3 сая ам.доллар, нийтийн тээврийн хэрэгсэл 43.2 сая ам.доллараар буурсан байна.


ЗУРАГ 3. ЭКСПОРТ, ИМПОРТ, сараар



Экспорт 2025 оны 6 дугаар сард өмнөх сараас 26.9 (2.3%) сая ам.доллар, импорт 7.4 (0.7%) сая ам.доллараар тус тус өссөн байна.

Харин өмнөх оны 6 дугаар сараас экспорт 348.7 (22.8%) сая ам.доллараар буурч, импорт 5.2 (0.5%) сая ам.доллараар өссөн байна.

ЗУРАГ 4. ЭКСПОРТ, ИМПОРТЫН БҮТЭЦ, 2025 оны эхний 6 сард, дүнд эзлэх хувиар



Эрдэс бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл гоёлын зүйлс болон үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 96.1 хувийг эзэлж байгаа бол импортын 72.0 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик

төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн эзэлж байна.


ХҮСНЭГТ 2. ЭКСПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-VI		2025* I-VI		2025* I-VI / 2024 I-VI	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Зөрүү	Хувь
		сая ам.доллар					
Нийт			7 889.3		6 581.4	- 1 307.9	- 16.6
Эрдэс бүтээгдэхүүн			7 016.2		5 813.6	- 1 202.6	- 17.1
Чулуун нүүрс	сая т	39.4	4 675.4	35.1	2 556.9	- 2 118.5	- 45.3
Зэсийн хүдэр, баяжмал	мян.т	785.2	1 454.4	1 053.6	2 352.3	897.9	61.7
Төмрийн хүдэр, баяжмал	мян.т	3 596.0	292.5	3 856.4	275.8	- 16.7	- 5.7
Боловсруулаагүй газрын тос	мян.барр	2 065.1	165.8	1 786.2	134.4	- 31.4	- 19.0
Жоншны хүдэр, баяжмал	мян.т	583.8	130.3	797.3	153.1	22.8	17.5
Цайрын хүдэр, баяжмал	мян.т	62.1	85.4	74.6	114.1	28.7	33.6
Молибдены хүдэр, баяжмал	мян.т	3.2	48.7	2.7	42.6	- 6.1	- 12.6
Хүрэн нүүрс	мян.т	1 173.2	50.0	2 795.9	95.9	46.0	92.0
Сувд, үнэт ба хагас үнэт чулуу			362.1		416.6	54.5	15.0
Алт	т	5.0	356.0	4.2	411.9	55.9	15.7
Мөнгө	т	1.6	1.3	1.6	1.8	-	32.9
Нэхмэл эдлэл			210.2		64.5	- 145.7	- 69.3
Самнасан ноолуур	т	278.5	28.4	452.0	42.3	13.9	48.8
Угаасан ноолуур	мян.т	2.7	148.0	-	-	- 148.0	-
Хонины ноос	мян.т	1.9	2.1	1.2	1.3	- 0.8	- 37.7
Амьд мал, амьтад			60.1		45.1	- 14.9	- 24.8
Хонь, ямааны мах	мян.т	8.2	30.7	1.8	6.4	- 24.3	- 79.1
Адууны мах	мян.т	5.0	17.6	7.9	28.0	10.4	59.4
Богийн өлөн гэдэс	т	274.1	6.3	354.3	7.8	1.5	24.5


Төрөл	Хэмжих нэгж	2024 I-VI		2025* I-VI		2025* I-VI / 2024 I-VI	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Зөрүү	Хувь
Бусад мал, амьтад	тол	2.0	0.0	2.0	0.0	-	0.0
Ургамлын гаралтай			26.8		60.5	33.7	2.3**
Рапс	мян.т	31.8	19.2	33.0	19.0	- 0.2	- 1.0
Самар	мян.т	0.5	7.3	2.6	36.8	29.5	5.0**
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн			36.3		31.1	- 5.2	- 14.3
Лаазалсан махан бүтээгдэхүүн	мян.т	7.1	32.0	5.5	24.8	- 7.2	- 22.5
Бусад хүнсний бүтээгдэхүүн			1.1		0.7	-	- 36.7
Үр тарианы хаягдал	мян.т	1.2	0.2	11.9	2.1	1.9	10.2**
Бусад			177.5		149.9	- 27.6	- 15.5
Тунгаасан зэс ба хайлш	мян.т	6.1	52.9	7.4	67.1	14.1	26.7
Суудлын автомашин	ш	269.0	9.0	79.0	1.1	- 7.9	- 87.9
Бульдозер, эксковатор зэрэг	ш	8.0	1.1	9.0	6.0	4.9	5.3**

** Дахин их

ЗУРАГ 5. ЭКСПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, сараар, биет хэмжээгээр



ЗУРАГ 6. ЭКСПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ





2025 оны эхний 6 сарын хилийн дундаж үнийн үзүүлэлт: Алтны үнэ өмнөх оны мөн үеэс унци тутамд 762.5 ам.доллар, зэсийн хүдэр, баяжмалын үнэ тонн тутамд 359.0

ам.доллаар тус тус өсөж, төмрийн хүдэр, баяжмалын үнэ тонн тутамд 9.7 ам.доллар, нүүрсний үнэ тонн тутамд 47.3 ам.доллаар буурсан байна.

ХҮСНЭГТ 3. ЭКСПОРТ, гол түнш улсаар

Улс орон	2023 I-VI		2024 I-VI		2025* I-VI	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
	сая ам.доллар					
Дүн	7 553.6	100.0	7 889.3	100.0	6 581.4	100.0
БНХАУ	7 015.5	92.9	7 313.9	92.7	6 031.9	91.7
Швейцарь улс	263.8	3.5	340.9	4.3	342.2	5.2
АНУ	3.7	0.0	17.6	0.2	76.1	1.2
ОХУ	48.6	0.6	55.3	0.7	29.5	0.4
Итали	30.3	0.4	24.6	0.3	16.3	0.2
Бусад	191.7	2.5	136.9	1.7	85.4	1.3

* Урьдчилсан гүйцэтгэл

БНХАУ-д экспортолсон барааны 44.0 хувийг нүүрс, 39.0 хувийг зэсийн хүдэр, баяжмал эзэлж байгаа бол Швейцарь улсад экспортолсон барааны 99.4 хувийг боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт эзэлж байна.

ЗУРАГ 7. ЗЭСИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН ЭКСПОРТ, боомтоор



2025 оны эхний 6 сарын байдлаар зэсийн хүдэр, баяжмалын экспортод Гашуун сухайт боомтоор экспортолсон зэсийн хүдэр, баяжмалын эзлэх хувь 71.0 болж, өмнөх оны мөн үеэс 9.0 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 4. ИМПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-VI		2025* I-VI		2025* I-VI 2024 I-VI	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Зөрүү	Хувь
		сая ам.доллар					
Нийт			5 378.1		5 528.2	150.1	2.8
Эрдэс бүтээгдэхүүн			1 201.1		1 124.5	-76.6	-6.4
Нефтийн бүтээгдэхүүн	мян.т	1 295.5	1 060.1	1 308.7	982.8	-77.3	-7.3
Цахилгаан эрчим хүч	сая квт.ц	1 372.1	99.4	1 388.7	103.3	3.9	3.9
Цемент	мян.т	118.4	7.4	71.0	4.6	-2.7	-36.9
Машин, механик төхөөрөмж			1 130.7		1 137.2	6.5	0.6
Цахилгаан шуудан утасны аппарат	мян.ш	430.1	137.2	508.9	141.4	4.2	3.1
Бульдозер, эксковатор зэрэг	мян.ш	1.6	166.8	2.0	138.5	-28.2	-16.9
Шороо, чулуу ялгах, холих машин	мян.ш	149.5	76.1	190.6	86.6	10.4	13.7
Компьютер, түүний бүрдэл хэсэг	мян.ш	230.1	57.0	106.4	43.0	-14.0	-24.5
Тээврийн хэрэгсэл, эд анги			1 126.9		1 229.0	102.0	9.1
Суудлын автомашин	мян.ш	57.4	460.9	63.0	668.5	207.6	45.1
Ачааны автомашин	мян.ш	14.2	336.9	13.1	292.6	-44.3	-13.2
Тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги	мян.ш	733.3	32.7	893.9	54.7	21.9	67.1
Үндсэн төмөрлөг			463.2		487.3	24.2	5.2
Арматур, катанка	мян.т	178.1	111.1	293.5	171.5	60.4	54.3
Хар төмөр бүтэц, эд анги			87.6		77.0	-10.5	-12.0
Бусад			1 456.3		1 550.3	94.0	6.5
Тун хэлбэрт савлагдсан эм		-	73.5	-	82.5	9.0	12.3
Бусад хүнсний бүтээгдэхүүн		-	53.8	-	62.1	8.3	15.3
Амтлаг гурилан зүйлс	мян.т	11.0	36.0	12.7	43.3	7.3	20.3
Шинэ дугуй	мян.ш	168.6	57.1	202.2	49.9	-7.2	-12.6
Янжуур	сая ш	1 736.7	33.8	1 937.6	36.8	3.1	9.2

* Урьдчилсан гүйцэтгэл

Импортын дүнд 2025 оны эхний 6 сарын байдлаар БНХАУ 38.3%, ОХУ 23.6%, Япон 12.7%, БНСУ 4.3%, АНУ 4.1%, ХБНГУ 2.5 хувийг тус тус эзэлж, нийт импортын 85.6 хувийг бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 5. ИМПОРТ, гол түнш улсаар


Улс орон	2023 I-VI		2024 I-VI		2025* I-VI	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
	сая ам.доллар					
Дүн	4 273.4	100.0	5 378.1	100.0	5 528.2	100.0
БНХАУ	1 675.1	39.2	2 194.9	40.8	2 119.5	38.3
ОХУ	1 136.6	26.6	1 362.8	25.3	1 306.1	23.6
Япон	340.3	8.0	515.5	9.6	703.7	12.7
БНСУ	195.8	4.6	221.7	4.1	239.4	4.3
АНУ	153.6	3.6	191.4	3.6	226.7	4.1
ХБНГУ	106.9	2.5	112.0	2.1	138.1	2.5
Бусад	665.0	15.6	779.9	14.5	794.7	14.4

* Урьдчилсан гүйцэтгэл

2025 оны эхний 6 сарын байдлаар ОХУ-аас импортолсон барааны 71.6 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон

барааны 80.3 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны 8.7 хувийг ачааны автомашин тус тус эзэлж байна.

ЗУРАГ 8. АЧААНЫ АВТОМАШИНЫ ИМПОРТЫН ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ



2025 оны эхний 6 сарын байдлаар ачааны автомашины импортын хилийн дундаж үнэ ширхэг тутам 22.0 мянган ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс ширхэг тутамд 509.7 ам.доллараар буурсан байна.

ХҮСНЭГТ 6. ЭКСПОРТ, ИМПОРТ, 2025 оны эхний 6 сард, боомтоор

Боомт	Экспорт		Импорт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
	сая ам.доллар			
Нийт	6 581.4	100.0	5 528.2	100.0
Алтанбулаг	36.5	0.6	358.3	6.5
Арцсуурь	0.1	0.0	0.0	0.0
Байтаг	0.1	0.0	0.1	0.0
Баянхошуу	125.8	1.9	5.1	0.1
Бичигт	160.8	2.4	10.0	0.2
Боршоо	0.3	0.0	14.9	0.3
Булган	4.5	0.1	29.4	0.5
Бургастай	12.5	0.2	0.2	0.0
Буянт-Ухаа	9.4	0.1	51.1	0.9
Гашуун сухайт	3 347.4	50.9	354.0	6.4
Замын-Үүд	1 350.6	20.5	2 950.4	53.4
Сүхбаатар	20.2	0.3	1 138.4	20.6
Тэс	-	-	0.0	0.0
Хавирга	1.5	0.0	9.8	0.2
Ханги	133.5	2.0	7.1	0.1
Ханх	-	-	0.3	0.0
Ховд	160.8	2.4	0.6	0.0
Цагааннуур	6.7	0.1	39.7	0.7
Чингис хаан	449.2	6.8	385.8	7.0
Шивээ хүрэн	684.8	10.4	147.3	2.7
Эрээнцав	77.1	1.2	25.9	0.5

2025 оны эхний 6 сард экспортын 50.9 хувь Гашуунсухайт, 20.5 хувь Замын-Үүд боомтоор хийгдсэн нь нийт экспортын 71.4 хувийг эзэлж

байна. Импортын 53.4 хувийг Замын-Үүд, 20.6 хувийг Сүхбаатар боомтоор тус тус хийсэн нь нийт импортын 74.0 хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гадаад худалдааны барааны нийт эргэлт: Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

Гадаад худалдааны тэнцэл: Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Барааны импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Барааны реимпорт: Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно.

Барааны экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.

Барааны реэкспорт: Өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.

Дотоодын бараа: Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулалт хийснээс бусад Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр чөлөөт эргэлтэд байгаа гадаадын барааг оруулна.



Эх үүсвэр:

Гаалийн ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 8 дугаар сарын 11

Эдийн засгийн статистикийн газрын дарга
М.Оюунжаргал
Утас: (+976) 11-329271

Эдийн засгийн статистикийн газрын
Мөнгө, санхүү, үйлчилгээний статистикийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Ихэртөр
Утас: (+976) 51-266698



/StatisticMGL



information@nso.mn



7014-1212